

## ЯПОН ДАХЬ СОЛОНГОС ИРГЭДИЙГ УМАРД СОЛОНГОС РУУ ИЛГЭЭХ АСУУДЛААРХ АНУ-ЫН БАЙР СУУРЬ

*Д.Оюунцэцэг\**

***Abstract:** This paper focuses on the U.S.'s stance on repatriation of the Koreans in Japan to North Korea, as a major actor in this issue, based on differences in policies and positions taken by U.S. State Department and U.S. Embassy in (which?) Korea. The U.S. stance on this issue was different from the beginning of the issue and when it was resolved. At the beginning of the 1950s, the U.S. State Department has taken a non-intervention stance, showing a cautious attitude toward Japan, within the range of its Japan-centered East Asia policy. Regarding South Korea, they were taken a critical stance on Korea's opposition to the repatriation Koreans to North Korea. Totally different attitude toward Japan and Korea has prompted more Korean opposition to the repatriation issue and strained ties between the U.S. and South Korea. Unlike the stance of U.S. State Department, U.S. Embassy in (Which?) Korea understood the necessity for U.S. active participation in this matter and was in a position to support the requests and demands of the country of residence. By the time Japan and North Korea pushed for repatriation project, the U.S. had changed its stance and belatedly participated in, but did not make any progress. Ultimately, this issue was determined by U.S. role recognition and role assignment within the range of U.S. East Asian policy in the Cold War system.*

***Key words:** Repatriation of Korean in Japan to North Korea, Koreans in Japan, U.S. policy toward East Asia in the 1950s, ROK-Japan relations in the 1950s, ROK-U.S. relations in the 1950s, Korea-Japan talks.*

\* \* \*

БНСУ болон Японы хоорондын албан ёсны харилцаа 1951 оноос эхэлсэн боловч хоёр орны үндэстэн хооронд олон жилийн турш хуримтлагдсан таагүй сэтгэгдэл зэргээс шалтгаалан 1960-аад оныг хүртэл төдийлэн ахицтай алхамд хүрч чадаагүй билээ. Өмнөд Солонгосын тал Японыг өнгөрсөнд үйлдсэн эзлэн түрэмгийлэх үйлдэлдээ харамсаж гэмшсэн байдал ч болсон үзүүлэхийг шаардаж байсан бол япончууд Японы дарлалын үед тогтсон Солонгосын талаарх үзэл баримтлалаа хадгалсаар байсан хэрэг. Хоёр улсын харилцаанд Өмнөд Солонгос нь оюун санаа, ёс суртахуун, дорнын сэтгэлгээ талаас хандаж байсан бол Япон нь хууль эрхзүй, бодит байдал, өрнөдийн сэтгэлгээгээр хандаж байсан гэж судлаачид үздэг. Солонгосчууд өөрсдийн үзэж туулсан зовлон зүдгүүр, доромжлолын тухай хөндөж байсан бол япончууд Солонгосын олсон гэх материаллаг ашиг зэргийг хэлэлцэж байлаа. 1950-иад оны үеийн Япон, Өмнөд Солонгосын харилцаа нь үндэстэн хоорондын сэтгэл санааны зөрчилдөөн олон улсын харилцаанд хэрхэн нөлөөлдгийг тод томруун харуулсан жишээ болдог билээ.

\* МУИС, ШУС, ХУС, Ази Судлалын тэнхимийн багш, Сөүлийн их сургуулийн докторант.

Гэвч үнэндээ, Япон Өмнөд Солонгосын харилцаа нь хоёр талын ойлголт ямар ч байснаас үл хамааран хүйтэн дайны систем дэхь Америкийн гаргаж тавьсан үүрэг ролийн хуваарилалтын дагуу, Ази дахь бодлогын хүрээнд шийдэгдсэн болно. Зүүн Азид коммунист лагерийнхан нөлөөний хүрээгээ өргөжүүлж буйг зогсоохын тулд АНУ өөрийн холбоотон улсууд болох Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээж хэвийн болгохоор хичээж байсан хэдий ч Японы байр суурийг чухалчлан үзэж, илүү өндөрт тавьдаг байсан. Японыг гол цөмөө болгосон АНУ-ын Ази дахь бодлого нь И Сын Ман ерөнхийлөгчийн Японыг эсэргүүцэх үзэл баримтлалыг улам бүр бататгаж, улмаар тухайн үед Америк Өмнөд Солонгосын хооронд үүссэн зөрчил маргалдааны голлох хүчин зүйл болсон юм. Ялангуяа 1950-иад оны эхэн үед хийсэн “Энхтайвны шугам” хөрш залгаа далайн тэнгис дэх бүрэн эрхийн тухай И Сын Маны мэдэгдэл, Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх асуудал нь Япон Өмнөд Солонгосын зөрчилдөөн, цаашлаад хоёр орны асуудлыг тойрсон Америк болон Өмнөд Солонгосын зөрчилт байдал, И Сын Ман ерөнхийлөгчийн Японы талаарх ойлголт, үзэл баримтлалыг тэр чигээр нь харуулсан жишээ хэмээн тооцогддог байна.

Энэхүү өгүүлэлд авч үзэх Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх асуудал (цаашид солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал гэх) нь Япон болон Өмнөд Солонгосын харилцааг сэргээх уулзалт хэлэлцээрийн үеэр дэгдсэн юм. Уг маргаан дэгдээсэн асуудал нь хоёр талын 4 дэх удаагийн яриа хэлэлцээрээр хөндөгдөх үндсэн асуудлуудын жагсаалтанд бичигдэж, уг асуудлаас шалтгаалан яриа хэлэлцээр хаагдахад хүрч, мөн ямар ч болзолгүйгээр дахин нээгдэж байжээ.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг Японы Либерал-Ардчилсан Нам төвтэй консерватив хүчин болон Японы Социалист Нам гэх мэт шинэчлэлийн хүчин, түүнчлэн Япон дахь Солонгос иргэдийн холбоо зэрэг байгууллагуудын зүгээс хөндөж байсан бол 1956 оноос Япон болон Умард Солонгосын Улаан Загалмайн Нийгэмлэгээр дамжуулан хөтөлбөр болгон хэрэгжүүлж эхэлсэн арга.

БНСУ-ын Засгийн Газар энэ асуудал анх яригдаж эхэлсэн үеэс л эсэргүүцлээ илэрхийлж<sup>69</sup>, уг асуудал шийдэгдэх хүртэл энэ байр сууриа хадгалсаар ирсэн юм. 1959 оны 1 дүгээр сард, Японы Гадаад хэргийн сайд Фүжияма “Солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөр”-өө зарласны дараа эсэргүүцсэн байр сууриа эрс хатуу илэрхийлж, Умард руу илгээх хөтөлбөрийг зогсоохын төлөө дипломат бодлого, стратеги боловсруулан ажиллаж эхэлсэн. Өмнөд Солонгосын тал хүйтэн дайны өнцгөөс коммунизмыг эсэргүүцэх үзэл баримтлал, зүй тогтлыг өмнөө барин, Японы Умард Солонгостой тохиролцсон уг хөтөлбөрийг “улс төрийн хуйвалдаанаас хэтрэхгүй зүйл” хэмээн буруушааж, “БНСУ-ын Засгийн Газар нь солонгос иргэдийг хүмүүнлэгийн үүднээс илгээх асуудлаар харилцан тохиролцох эрхтэй”<sup>70</sup> хэмээн эрс эсэргүүцэж байлаа. Японы хувьд “Япон дахь солонгос иргэдийг Умард

<sup>69</sup> 제일한인 송환문제에 관한 대한적십자사 총재의 답신, 1956-9-4, 분류번호: 731 JA 북 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0007-0011, 영약 0012-0013, 한국어.

<sup>70</sup> 제일한인 송환문제에 관한 대한적십자사 총재의 답신, 1956-9-4, 분류번호: 731 JA 북 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0007-0011, 영약 0012-0013, 한국어.

руу илгээх хөтөлбөр нь бусад гадаад иргэдийн нэгэн адил хүмүүнлэгийн хүрээнд, хувь хүний үзэл бодлыг хүндэтгэн үзэх зарчмын дагуу хэрэгжинэ”<sup>71</sup> гэсэн байр суурийг хөтөлбөр хэрэгжиж дуустал барьж байсан бол Америкийн тал “АНУ-ын Засгийн Газар нь хувь хүний хүсэл зориг, чөлөөт сонголтонд үндэслэсэн нутаг буцаах зарчмыг дэмжих болно”<sup>72</sup> гэж мэдэгдэж байжээ.

Японы Сайд нарын танхимын 1959 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг хэлэлцэж батлан, мөн оны 4 дүгээр сараас эхлэн Швейцарийн Женев хотноо Япон болон Умар Солонгосын Улаан Загалмайн Нийгэмлэг хооронд уг асуудлаарх албан ёсны яриа хэлэлцээр эхэлсэн юм. Америкийн зүгээс уг хэлэлцээрт Олон Улсын Улаан Загалмайн Нийгэмлэгийн Олон Улсын Зөвлөлийг оролцуулахаар хичээсэн боловч 8 дугаар сарын 13-ны өдөр хоёр тал ОУУЗН-ийн оролцоогүйгээр солонгос иргэдийг Умард руу илгээх тухай хэлэлцээрт гарын үсэг зурав. БНСУ-ын Засгийн газраас солонгос иргэдийг Умард руу илгээхийг бүрмөсөн зогсоох талаар тал бүрийн оролдлого хийсэн хэдий ч амжилтанд хүрсэнгүй.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаар хийгдсэн судалгаанууд уг асуудлаарх БНСУ-ын байр суурь, Умард руу илгээхийг зогсоох оролдлого үр дүнгүй болсон нь АНУ-ын талаас Японыг дэмжиж, солонгос иргэдийг Умард руу илгээхийг хүлээн зөвшөөрсөн явдал, цаашлаад тухайн үеийн Зүүн Азийг тойрсон олон улсын харилцааны систем дэх Өмнөд Солонгосын байр суурь, гадаад нөөц боломж, дипломат чадвар чадамжтай холбоотой асуудал хэмээн дүгнэсэн байдаг (이완범, 2005; 이현진, 2008, 2010; 신옥희, 2010; 강여린, 2013). Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх ажиллагаа нь 1955-1984 оныг хүртэл үргэлжилсэн бөгөөд нийт 93340 солонгос гаралтай иргэнийг Умард Солонгос руу шилжүүлсэн байна. Умард руу илгээх ажлын 80 хувь нь 1959-1961 оны хооронд явагджээ (박정진, 2011).

Дайны дараах иргэдийг бөөнөөр шилжүүлэх жишээ болохын хувьд хүйтэн дайны систем дэх үзэл суртлын хоёр лагерь болоод дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байсан солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал нь жил ч хүрэхгүй хугацааны дотор шийдэгдсэн юм. Умард Солонгосоос оргон зугатсан солонгос иргэдийн асуудал зэрэг өнөөдрийг хүртэлх урт хугацааны үр дагавар дагуулсан богино хугацааны тэрхүү шийдвэрт тухайн үеийн Япон, Өмнөд Солонгосын харилцааг шийдвэрлэж байсан Америкийн байр суурь нөлөө бүхий хувьсагч болсон нь тодорхой юм. Тиймээс ч энэхүү асуудлын талаарх АНУ-ын баримталсан бодлого, байр сууринд анхаарлаа хандуулан, уг асуудлаар хийгдсэн судалгааны ажлуудыг судалж үзлээ.

Гуч орчим жил үргэлжилсэн солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалтай холбогдолтой БНСУ, АНУ, Японы гадаад харилцааны бичиг баримт, баримт

<sup>71</sup> 최규하 이타카기와의 면담내용 보고, 공한 (TS-920288), 1959-1-30, 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 아주과, 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0032-0036, 영어

<sup>72</sup> Dillon, 제일한국인 북송문제는 자유의지에 기초하여 이루어져야 한다는 국무부의 입장 표명 국가안전위원회 한일회담 관계 미국무부문서7 (1959), 주한 미국 대사관 문서철 1959-06-27. p. 272

бичгүүдийн эмхэтгэл гэх мэт анхдагч эх сурвалжууд харьцангуй хуримтлагдсан байдаг ч эрдэм шинжилгээний судалгаа, ялангуяа олон улсын харилцааны өнцгөөс уг асуудлыг авч үзсэн судалгаа ховор болохыг судалгааны материал цуглуулах явцад анзаарсан юм. Солонгос иргэдийн Умард руу илгээх асуудлаарх холбогдох гурван улсын байр суурь, ойлголттой холбоотой судалгаанууд дотроос АНУ-ын байр суурийг голлон судалсан И Жинь Хёнь (2010), Кан Ё Рин (강여린, 2013) нарын судалгааг онцлон дурдууштай. Сэдвийн судлагдсан байдлын талаар дараагийн бүлэгт тодорхой авч үзэх болно.

Энэхүү судалгаа нь Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх тухай асуудлыг жишээ болгон сонгож, уг асуудлыг шийдвэрлэх үйл явц дахь голлох оролцогчдын нэг болох АНУ-ын оролцоо, байр суурь, тодруулбал АНУ-ын Төрийн Департамент болон БНСУ дахь АНУ-ын Элчин Сайдын Яамны байр суурийн ялгаатай талуудад анхаарлаа хандуулна. Судалгааны үндсэн бүлэг болох гурав, дөрөвдүгээр бүлэгт АНУ-ын Төрийн Департамент, БНСУ болон Япон улсад суугаа АНУ-ын Элчин Сайдын Яамдын хооронд солилцсон дипломат баримт бичгүүдэд тулгуурлан солонгос иргэдийг Умард руу илгээх тухай асуудал АНУ, БНСУ, Япон гурван улсын хувьд тулгамдсан асуудал болон хөндөгдөж ирсэн үе болоод уг асуудал шийдэгдэх үйл явц дахь АНУ-ын байр суурь, оролцоог авч үзэх юм. Судалгааны дүгнэлт хэсэгт АНУ-ын Төрийн Департамент болон БНСУ дахь ЭСЯ-ны байр суурь, хоорондын ялгааг тодорхойлж, уг ажлын ач холбогдлыг дүгнэн үзэх болно.

Уг судалгааны зорилгод хүрэхийн тулд БНСУ-ын Гадаад Хэргийн Яамны архивын бичиг баримтууд дотроос Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээхтэй холбоотой бичиг баримтууд (723.1 JA 북 V.2,3,4,6) болон АНУ-ын Төрийн Департаментын Архивын Дипломат Төлөөлөгчийн Газруудын бичиг баримтууд (Record Group 84) дотроос БНСУ-д суугаа АНУ-ын Элчин Сайдын Яамны бичиг баримтууд<sup>73</sup> хийгээд Япон улсад суугаа АНУ-ын Элчин Сайдын Яамны бичиг баримтууд<sup>74</sup> зэрэг анхдагч эх сурвалжуудыг голлон ашиглаж, түүхэн анализ судалгааны аргыг хэрэглэсэн болно.

Тухайн үеийн АНУ болон БНСУ-ын дипломат төлөөлөгчийн газруудын хооронд харилцаж байсан бичиг баримт зэрэг анхдагч эх сурвалж ашиглан Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх АНУ-ын баримталсан бодлого, тэр дундаа шийдвэрлэх үйл явц дахь АНУ-ын гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болох Төрийн Департамент болон түүний харьяа гүйцэтгэгч байгууллага болох БНСУ дахь Дипломат Төлөөлөгчийн Газрын байр суурийн ялгаатай талуудыг анхааран судалснаар уг асуудлаарх өмнөх судалгаануудад орхигдсон талуудыг нөхөж, өмнөх судалгааны үр дүнг дахин нотлоход уг судалгааны ажлын эрдэм шинжилгээний ач холбогдол оршино.

<sup>73</sup> 국사편찬위원회, 「한일회담관계 미 국무부 문서 7 (1959) 주한미국대사관문서철」, 2010

<sup>74</sup> 국사편찬위원회, 「한일회담관계 미 국무부 문서 5,6 (1959) 주일미국대사관문서철」, 2010

### Сэдвийн судлагдсан байдал

Гуч орчим жил үргэлжилсэн солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалтай холбогдолтой БНСУ, АНУ, Японы гадаад харилцааны бичиг баримт, баримт бичгүүдийн эмхэтгэл, Умард руу илгээх хөтөлбөрт оролцож байсан нийгмийн зүтгэлтнүүдийн дурдатгал, дурсамж зэрэг судалгааны анхдагч эх сурвалжууд харьцангуй хуримтлагдсан байдаг ч эрдэм шинжилгээний судалгаа цөөн болохыг судалгааны материал цуглуулах явцад анзаарсан юм. Уг асуудлаарх судалгаа голдуу япон, солонгос эрдэмтдийн хүрээнд явагддаг байна.

Энэхүү ажлын хүрээнд солонгос хэл дээрх судалгааны ажлуудыг голчлон судалж үзсэн. Олон улсын харилцааны өнцгөөс харсан судалгаа харьцангуй цөөн байдгийн дотор солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх БНСУ, АНУ, Японы ойлголт болон байр суурьтай холбоотой И Хён Жинь (이현진, 2008, 2010), Кан Ё Рин (강여린, 2013), мөн олон улсын харилцааны бусад асуудалд солонгос иргэдийг умард руу илгээх асуудлыг хавсруулан авч үзсэн И Жэ У (이재우, 1984), Шинь Ыг Хи (신옥희, 2004, 2010), У Иль Хуан (오일환, 2005), Рюү Ми На (류미나, 2008) нарын судалгаа анхаарал татаж байв. Түүнчлэн солонгос иргэдийг Умард руу илгээх бодлогын талаарх Жинь Хи Гуань (진희관, 2002), И Уань Бом (이완범, 2005), уг хөтөлбөрийн талаарх Пак Жон Жинь (박정진, 2011) Мацүра Масанобү (마츠우라 마사노부, 2015) нарын судалгаанаас гадна Умард Солонгосын Японтой харилцах оролдлого болон Умард Солонгосын ажиллах хүчний хомсдолтой холбоотойгоор уг асуудлыг судалсан Пак Жон Жинь (박정진, 2008, 2010) судлаачийн ажлуудыг дурдаж болно.

Японы судлаачдын хувьд Япон ба Умард Солонгосын харилцаа, Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх бодлого, уг асуудлаарх Японы Өмнөд Солонгосын талаар баримталсан бодлого, Умард руу илгээх хөтөлбөрт Улаан Загалмайн Нийгэмлэг болон Япон дахь Солонгос Иргэдийн Холбооны үүрэг рольтой холбоотой судалгаа голлосон байдаг байна (이완범, 2005)<sup>75</sup>.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх Америк, Өмнөд Солонгос, Японы ойлголт, талуудын баримталсан бодлого, байх суурь, хариу арга хэмжээ зэргийг олон улсын харилцааны бүтэц, дэг журмын хүрээнд Япон Өмнөд Солонгосын хэлэлцээрийн үйл явцаар дамжуулан авч үзсэн И Хён Жинь (이현진, 2008; 2010) судлаач нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал болон Япон Өмнөд Солонгосын хэлэлцээртэй холбоотой нийтэд нээлттэй болсон дипломат баримт материалуудыг ашигласнаараа харьцангуй бодит, баримт нотолгоотой анализ хийхийг оролдсоноороо шинэлэг судалгаа хийж чадсан юм. Харилцан нөхсөн үр дүнд хүрсэн гэж хэлж болох цуврал судалгаа нь дараах дүгнэлтийг гаргажээ. Солонгос иргэдийг Умард руу шилжүүлэх бодлого нь хэдийгээр оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх чөлөө хэмээх хүмүүнлэгийн зарчмыг баримтлан хэрэгжүүлсэн гэх ч ОУУЗН-ийн оролцоог зөвшөөрөх эсэх асуудлаар Японы Засгийн газар дээрх зарчмаасаа ухарсан шийдвэр гаргасан нь уг асуудалд улс төрийн

<sup>75</sup> 이완범, 「제일교포 북송문제 연구」, 『해방후 한일관계의 쟁점과 전망』, 경인문화사, 서울, 2005.

болоод бодит ашгийн зүй тогтлын үүднээс хандаж, хэрэгжүүлсэн, цаашлаад энэ асуудлаар дамжуулан хоёр улсын хэлэлцээрт илүү ашигтай байр сууринаас хандах гэсэн санааг агуулж байсан гэж үзжээ. Тэрээр энэ асуудлыг шийдвэрлэхэд АНУ-ын нөлөө чухал үүрэг гүйцэтгэсэн гээд АНУ-ын Зүүн Ази дахь бодлогод Япон Өмнөд Солонгосын харилцааг хэвийн болгох явдал нь тулгамдсан асуудал болоод байгаа нөхцөл байдалд солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаас шалтгаалан тасрахад хүрсэн Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин нээхэд зуучилж өгсөн нь хоёр талын цаашдын маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцох байдал үзүүлсэн гэж дүгнэжээ. БНСУ-ын Засгийн газар уг асуудлыг олон улсын харилцаан дахь систем хоорондын өрсөлдөөний хүрээнд ойлгож, хүйтэн дайны өнцгөөс харж дэлхий дахины аюулгүй байдалд учруулах аюул занал хэмээн үзсэн боловч эцсийн дүндээ Японы тал Умард руу илгээх хөтөлбөрөө идэвхжүүлж, Америкийн тал тэрхүү хөтөлбөрийг хүлээн зөвшөөрөх болсон нь өмнөд Солонгосын хүчин зүтгэлийг бүтэлгүйтэхэд хүргэсэн юм. Тиймээс ч судлаач И Хён Жинь Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоох боломжгүй болсон нь тухайн үеийн Зүүн Азийг тойрсон олон улсын харилцааны систем дэх БНСУ-ын Засгийн газрын чадвар чадамж хязгаарлагдмал байсныг дурдаад уг асуудлаар тодорхой бодлого байгаагүй нь солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоох арга хэмжээ авч чадаагүйн үндэс болсон гэж дүгнэжээ.

Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх АНУ-ын байр суурийг голчлон судалсан Кан Ё Рин (2013) судлаачийн судалгааг онцлон дурдууштай юм. Кан Ё Рин (2013) нь АНУ-ын Төрийн Департамент болон Дипломат Төлөөлөгчийн Газрын бичиг баримтуудад түшиглэн судалгаа хийхдээ АНУ-ын байр суурийн өөрчлөлтийг төвийг сахисан байр суурь, идэвхгүй оролцоо, идэвхтэй оролцоо хэмээн дүгнэж, өөрчлөлтийн учир шалтгааныг судалж үзсэн юм. Умард руу илгээх бодлогыг Зүүн Хойд Ази дахь жижиг асуудал хэмээн үзсэн АНУ-ын төвийг сахисан байр суурь 1959 оны 4 дүгээр сард Женев хотноо Япон болон Умард Солонгосын УЗН-ийн хэлэлцээр эхэлсэн үеэс идэвхгүй оролцоо болон өөрчлөгдөх болж, 1959 оны 6 дугаар сарын сүүлч, Умард руу илгээх хөтөлбөр хэрэгжих нь тодорхой болж, Япон-Өмнөд Солонгосын харилцаа улам бүр муудах үеэс идэвхтэй оролцоо болон өөрчлөгдсөн гэж тодорхойлжээ. Судлаач АНУ-ын байр суурь ийнхүү өөрчлөгдсөн шалтгааныг юу юунаас илүү хүйтэн дайны систем дэх Япон, Өмнөд Солонгосын харилцааг сайжруулахын төлөөх хүчин чармайлт байсан боловч, тэрхүү хүчин зүтгэл талаар болсон нь 1959 оны 8 дугаар сард, Япон болон Умард Солонгосын УЗН-ийн хооронд Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх тухай хэлэлцээр байгуулагдсантай холбоотой хэмээн дүгнэжээ.

Судлаач Жинь Хи Гуань (2002) нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлын гол тоглогч болох Япон болон Умард Солонгосын УЗН, Япон дахь солонгос иргэдийн холбооны үйл ажиллагааг голлон Умард руу илгээх асуудлыг авч үзсэн байна. Тэрээр уг асуудлыг Япон болон Умард Солонгосын харилцаагаа сэргээх гэсэн оролдлого, Япон дахь солонгос иргэдийн чөлөөт сонголтын үр дүн гэдэг

өнцгөөс харж, дүгнэсэн бөгөөд Япон дахь солонгос иргэдийн Умард Солонгосыг сонгосон явдал нь үзэл сурталтай холбоогүй байсан хэмээн үзсэн байдаг.

И Уань Бом (2005) судлаачийн хувьд, БНСУ-ын Засгийн газрын умард руу илгээхийг зогсоохын төлөөх хүчин зүтгэл нь АНУ-ын Японы бодлогыг дэмжсэн явдал болоод Японы Өмнөд Солонгостой гадаад худалдаагаа зогсоох арга хэмжээ зэргээс шалтгаалан амжилтгүй болохоос өөр аргагүйд хүрсэн гээд энэ асуудлыг улс төрийн асуудал хэмээн үзэж, хүмүүнлэг болон иргэдийн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчмыг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас тухайн үед Өмнөд Солонгос олон улсын нийгэмлэгээс тусгаарлагдсан байсантай ч холбоотой гэж дүгнэжээ.

Пак Жон Жинь (2008, 2010) судлаачийн судалгаанууд нь Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг Япон-Умард Солонгосын харилцаа болон Умард Солонгосын Японы талаар явуулсан бодлоготой холбож үзсэн байдаг. Тэрээр Умард Солонгос Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийн сул орон зайг ашиглан, солонгос иргэдийг Умард руу шилжүүлэх ажиллагааг явуулснаар Японтой харилцах харилцаандаа харьцангуй том ололт амжилт олсон гэж дүгнэжээ. Умард Солонгос нь Япон дахь солонгос иргэдийн холбоонд түшиглэсэн Япон дахь солонгос иргэдийн хөдөлгөөн, Япон, Умард Солонгосын нийгэмлэгээс зохион байгуулсан шинэчлэлийн хөдөлгөөн зэргийг гол тэнхлэгээ болгож, Японтой харилцаагаа хэвийн болгох зорилгоор Японтой ардын дипломат ажиллагаа (олон нийтийн дипломат ажиллагаа) идэвхтэй явуулж байсны нэг жишээ байсан гэж үзсэн байна.

Мацүра Масанобу (2015) нь солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийн үйл явц, Умард руу явсан иргэдийн хувийн болоод бүлгийн санаа, үзэл бодлын өөрчлөлтийг судлах зорилгоор Умард Солонгосоос Японд байгуулсан зохион байгуулалт бүхий бүтэц болох Япон дахь солонгос иргэдийн холбоо, Умард Солонгосыг дэмжигч нийгмийн бусад хөдөлгөөнүүдийн үйл ажиллагааг голлон судалсан байдаг.

Сонирхол татсан нэгэн судалгаа бол У Иль Хуан (2005) судлаачийн Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээхээс өмнө Зүүн Хойд Азид өрнөсөн бөөнөөр шилжүүлэх ажиллагаанууд, тухайлбал Хятад дахь япон иргэдийг нутаг буцаах, Япон дахь хятад иргэдийг Хятадын эх газар руу илгээх асуудлыг судалсан жишээ судалгаа юм. Судлаач Хятад дахь япон иргэд, Япон дахь хятад иргэдийг нутаг буцаах тухай 1953 оны Бээжингийн хэлэлцээр нь ЗХУ болон Умард Солонгост нөлөөлсөн гэж үзжээ. 1953 оны эцсээр ЗХУ болон Японы УЗН хооронд ЗХУ дахь япон иргэдийг нутаг буцаах тухай Москвагийн хэлэлцээр байгуулагдсан бол 1955 онд Умард Солонгосын зүгээс өөрийн нутаг дахь япон иргэдийг нутаг буцаах тухай асуудлаар хэлэлцээр байгуулах саналыг Японы талд тавьж, 1956 оны Пёняны хэлэлцээрийг байгуулсан байна (오일환, 2005;144-145). Ийнхүү УЗН хооронд байгуулагдсан Бээжингийн хэлэлцээр нь Пёняны хэлэлцээрээр үргэлжлэн

улмаар Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх тухай 1959 оны Женевийн хэлэлцээрт нөлөөлсөн гэж үзсэн байна.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг хавсарга маягаар авч үзсэн судалгаанууд дотроос Шин Үг Хи (2004, 2010) профессорын судалгаа анхаарал татна. Тэрээр Япон, Өмнөд Солонгосын 4 дэх удаагийн уулзалт хэлэлцээрийн үеэр дэгдсэн солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаар дамжуулан И Сын Ман ерөнхийлөгчийн Японы талаарх ойлголт, АНУ-ын өмнөд Солонгосын үүрэг ролийн хуваарилалт хоёрын ялгааг олж харахыг оролдсон юм. Энэхүү судалгаанаас И Сын Ман ерөнхийлөгчийн Японы талаарх ойлголт шууд нөлөөлж байсан хийгээд уг асуудлаар АНУ-ын Японыг дэмжсэн байр сууринд шүүмжлэлтэй хандаж байсан зэрэг нь солонгос иргэдийг умард руу илгээх асуудлаарх БНСУ-ын баримталсан байр суурь, эрс эсэргүүцэл, түүнийг зогсоох гэсэн оролдлогод шууд нөлөөлж байсныг мэдэж болно.

2017 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотноо зохиогдсон Ази судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр хэлэлцүүлсэн Д.Оюунцэцэг (2017)-ийн илтгэлд уг асуудлаарх БНСУ-ын баримталсан бодлого, байр суурийг онцлон авч үзсэн юм. Япон дахь хятад иргэдийг Хятад руу шилжүүлэх асуудлыг чимээгүй хүлээн зөвшөөрсөн Тайваниас ялгаатай нь<sup>76</sup> БНСУ-ын Засгийн Газар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг тууштай эсэргүүцэж, зогсоох оролдлогуудыг идэвхтэй хийж байсан төдийгүй асуудал шийдэгдсэний дараа, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хойно ч олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан, уг асуудлыг зогсоох боломж, арга замыг эрэлхийлж байсныг холбогдох бичиг баримтуудыг үндэслэн гаргаж тавьсан байна.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд уг асуудлаарх АНУ-ын байр суурийг авч үзэхдээ гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллага хоорондын байр суурийн ялгаатай талуудыг онцлон авч үзэхдээ оршил бүлэгт дурдсанчлан, энэхүү өгүүллэгийн үндсэн хэсэг болох гурав, дөрөвдүгээр бүлэгт холбогдох байгууллагуудын хооронд солилцсон ноот бичиг, илтгэл, тайлан, протокол, албан мэдэгдэл зэрэг дипломат баримт бичгүүдэд тулгуурлан анализ хийх болно. Япон дахь солонгос иргэдийг Умард руу шилжүүлэхтэй холбоотой бичиг баримтуудыг хянаж үзэхэд АНУ-ын Төрийн Департаментаас БНСУ-д суугаа ЭСЯ-нд илгээсэн албан бичиг асуудал хөндөгдөж эхэлсэн үеэс 1959 оны 3 дугаар сарыг хүртэл хуруу дарам цөөн байсан бол 4 дүгээр сарын дунд үеэс ОУУЗН-тэй холбоотой албан бичгүүд голлож, 6 дугаар сараас эхлэн асуудал шийдвэрлэгдэх хүртэл уг асуудлаарх заавар зөвлөмж бүхий ноот бичгүүд эрс нэмэгдсэн байдал ажиглагдсан болно.

Энэхүү өгүүлэлд эх сурвалж болгон ашигласан Америк, Өмнөд Солонгосын дипломат бичиг баримтуудад дурдагдах эрх бүхий холбогдох албан тушаалтнуудыг дурдвал, АНУ-ын талаас, Төрийн нарийн бичгийн даргын орлогч (1959.4.22-ноос

<sup>76</sup> Ижил төстэй өмнөх тохиолдлууд, тухайлбал Япон дахь хятад иргэдийг эх газар руу илгээхтэй холбоотой асуудлыг Тайваны тал эсэргүүцэж байсан ч чимээгүй хүлээн зөвшөөрөөд өнгөрсөн (오일환, 2005).

Төрийн нарийн бичгийн дарга болсон) Christian A. Herter, Douglas C. Dillon, БНСУ-д суугаа элчин сайд Walter S. Dowling, Япон улсад суугаа элчин сайд Douglas McArthur II, Төрийн Департментын зөвлөх Walter S. Robertson, Төрийн Департментын Алс дорнодын газрын дарга Graham J. Parsons, БНСУ-д суугаа ЭСЯ-ны зөвлөх Sam P. Gilstrap, БНСУ-ын талаас БНСУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ким Дун Жү, АНУ-д суугаа элчин сайд Ян Юү Чнь, Японд суугаа элчин сайд Юү Тэ Ха, Японд суугаа ЭСЯ-ны зөвлөх Чүэ Гюү Ха, Японы талаас, Японы ерөнхий сайд Нобүсүкэ Киши, Японы Гадаад хэргийн сайд Айичиро Фүжияма, Японы Гадаад хэргийн яамны Азийн газрын дарга Осамү Итагаки нар болно.

**Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх асуудал хөндөгдөж  
эхэлсэн үе ба АНУ-ын байр суурь**

1950-иад оны АНУ-ын Япон, Өмнөд Солонгосын талаарх бодлого нь хүйтэн дайны системд зориулсан зохиомжийн дагуу явагдаж байв. Тавиад оны эхний хагаст, Зүүн Азид коммунизмын нөлөө өргөжин тэлэхийг зогсоох зорилгоор Японы байр суурийг чухалчлан үзэж байсан нь Сан Францискогийн энхтайвны гэрээн дэх Өмнөд Солонгосын оролцоог хязгаарлах хандлагаар илэрч байсан бол тавиад оны сүүл хагаст, эдийн засгийн хөгжлөөр дамжуулан системийн өрсөлдөөнд давамгайлах зорилго бүхий улс төр-эдийн засгийн бодлогынхоо хүрээнд Япон, Өмнөд Солонгосын харилцааг хэвийн болгохыг шавдуулахдаа Японы байр суурь, ашиг сонирхлыг ямагт дээгүүр тавьж байв. Ази дахь Япон төвт Америкийн гадаад бодлого болон И Сын Ман ерөнхийлөгчийн Японыг эсэргүүцэх үзэл баримтлал зэргээс шалтгаалан Америк, Өмнөд Солонгос хоорондын зөрчилт байдал үүссэн байсан (신욱희, 2004) бол Япон, Өмнөд Солонгосын тухайд асуудал нааштай эргэж байлаа.

1957 оны 12 дугаар сарын 31-ний өдөр, Япон болон Өмнөд Солонгос хоёр улсын харилцааг сэргээх тухай тохиролцоонд гарын үсэг зурснаар Японы тал Күботагийн хэлсэн үг<sup>77</sup> болон Өмнөд Солонгост ногдуулах хөрөнгийн нэхэмжлэлийг буцаан татаж, баригдсан хүмүүсийг харилцан суллах асуудлаар тохиролцоонд хүрч, Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлэхээр болсон юм. 1958 оны эхээр хоёр тал баригдсан хүмүүсийг харилцан суллаж, нутаг буцаах ажлыг хийж гүйцэтгэсний дараа 4 дүгээр сарын 15-ны өдөр Япон Өмнөд Солонгосын уулзалт хэлэлцээр дахин нээгдэж, 4 дэхь удаагийн яриа хэлэлцээр эхлэв. Гэвч яриа хэлэлцээр түр завсарлаж байх зуур Японы Гадаад хэргийн сайд Фүжияма Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх хөтөлбөрийн талаар албан ёсны мэдэгдэл хийжээ. Хоёр талын хэлэлцээрийн үеэр Япон дахь солонгос иргэдийн хууль эрх зүйн статустай холбоотой асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй Японы тал тус улсад суугаа солонгос иргэдийн амьжиргааны зардлыг танаж багасгах зорилгоор

<sup>77</sup> 1953 оны 10 дугаар сард Япон Солонгосын 3 дахь удаагийн хэлэлцээрийн үеэр нэхэмжлэх эрхийн асуудлаар явагдсан хуралдааны үеэр Японы төлөөлөгч Күбота Каничиро “Японы колоничлолын үед Солонгос олон талаар ашиг олсон. Солонгос нь Японоос нөхөн төлбөр шаардаж, япончуудын хөрөнгийг хураах нь олон улсын эрх зүйн талаас ярьвал өөр асуудал болно. Тэгээд ч Япон Солонгосыг өөртөө нэгтгээгүй бол өөр аль нэг улс Солонгосыг эзлэн түрэмгийлж, солонгос үндэстнүүд илүү өрөвдөлтэй байдалд орох байсан” гэж хэлжээ.

солонгос иргэдийг Умард руу илгээх хөдөлгөөнийг өрнүүлэх замаар олон нийтийн санаа бодолд нөлөөлж, улмаар энэхүү ажлыг бодитоор хэрэгжүүлэхээр шавдуулж эхэлсэн байжээ (이 현진, 2010; 74).

Ийнхүү Японы тал оршин суух газраа сонгох эрх чөлөө болон хүмүүнлэгийн зарчмаар түрүү барьж, Япон болон Хойд Солонгосын УЗН-ээр дамжуулан солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсноо зарласан нь Япон Өмнөд Солонгосын хэлэлцээрийг зогсонги байдалд оруулж, хоёр улсын харилцаан дахь зөрчилт байдлыг улам бүр гүнзгийрүүлсэн юм. Солонгосын хойг дахь хууль ёсны засгийн газар болохын хувьд Япон дахь солонгос иргэдийг харьяалах эрх бүхий БНСУ-ын Засгийн газар нь тэдгээр иргэдэд тохирох хэмжээний нөхөн төлбөр олгоогүй цагт солонгос иргэдийг хүлээн авахыг татгалзсан боловч, тэд харьяалалгүй иргэд биш тул зөвхөн Өмнөд Солонгос руу шилжүүлэх ёстой хэмээн үзэж байлаа.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал хөндөгдөж эхэлсэн эхэн үед АНУ-ын Төрийн Департаментээс БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ-нд уг асуудалтай холбоотой 4-5 албан бичиг илгээсэн байсан хэдий ч Япон болон БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ хооронд солилцсон ноот бичиг, албан захидал зэргээс Америкийн гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болох Төрийн Департаментын байр суурийг дүгнэн үзэж болох юм.

Японд суугаа АНУ-ын элчин сайд Дуглас Мак Артур (Douglas Mac Arthur) 1959 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Японы Гадаад хэргийн сайд Фүжияматай уулзан "... Япон, Өмнөд Солонгосын хооронд үүсээд байгаа хурцадмал байдал нь Умард Солонгосын коммунистуудын өдөөн хатгалгаас үүдэлтэй" гээд "... чөлөөт ертөнцийн эрх ашигт хохирол учруулалгүйгээр нөхцөл байдлыг шийдвэрлэхийг хүсье" хэмээн үзэл бодлоо илэрхийлээд "... Умард Солонгос хүмүүнлэгийн үүднээс бус харин чөлөөт ертөнцийнхнийг хуваахын төлөөх коммунист маягийн үндсэн стратегийнхаа хүрээнд зориуд хоёр орны харилцаанд бэрхшээл учруулж байгаа хэрэг юм"<sup>78</sup> хэмээн онцолжээ. Элчин сайд түүнээс хоёр хоногийн дараа Японы ерөнхий сайд Киши Нобусүкэтэй уулзаж ярилцахдаа Өмнөд Солонгосын байр суурийг бүрэн ойлгож байгаагаа түүнд илэрхийлсэн талаараа төвдөө тайлагнасан байна. Тэрээр солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаас шалтгаалан Америк, Өмнөд Солонгосын харилцаа ноцтой байдалд ороод байгааг дурдаад, "... Хэрвээ Япон Умард руу илгээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх аваас Японтой харилцаагаа бүр мөсөн таслах Өмнөд Солонгосын оролдлогыг би ойлгож байна."<sup>79</sup> гэжээ.

<sup>78</sup> MacArthur 주일 미대사의 후지야마 외상과의 면담내용 보고, 후지야마에게 전달 의견. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-09, pp. 8-11

... I expressed appreciation for Fujiyama's explanations and offered following comment: Present crisis between ROK and Japan seemed have its origin in North Korean communist campaign among their compatriots in japan in favor of repatriation. They obviously did not do this from humanitarian reasons... but obvious reason of creating difficulties between Japan and ROK as part of general communist strategy of dividing countries of free world. I said I shared Fujiyama's fear that repatriation to North Korea may lead to break in negotiations between Japan and ROK.

Therefore I hoped that everything possible would be done to manage affair in way which would minimize damage to important free world interests involved...

<sup>79</sup> MacArthur 주일미대사와 기시 수상의 대화 비망록, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-10. p. 12

Эндээс Америкийн тал Япон болон Умард Солонгосын хамтарсан солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийг хүйтэн дайны өнцгөөс харж, чөлөөт лагерийнхны эрх ашигт хохирол учруулахыг санаархагч коммунистуудын төлөвлөгөө хэмээн ойлгож байсныг, түүнчлэн элчин сайд яаран сандран Японы ерөнхий сайдад бараалхах болсон зэрэг нь энэхүү асуудал Америкийн хувьд дэл сул асуудал биш болсон зэргийг харуулж байгаа юм. Гэвч цагаан ордон Зүүн Ази дахь гол холбоотон улсууд болох Япон, Өмнөд Солонгосын харилцааны хурцадмал байдалд санаа зовж байсан хэдий ч асуудалд хөндлөнгөөс оролцох бодолгүй байсныг дараах албан бичгүүд нотолж байна.

1959 оны 2 дугаар сарын 11-ний өдөр, Япон улсад суугаа АНУ-ын ЭСЯ-наас БНСУ-д суугаа өөрийн улсын ЭСЯ-нд илгээсэн ноот бичигт<sup>80</sup> элчин сайд Мак Артур болон Японд суугаа БНСУ-ын элчин сайд Юү Тэ Ха нарын уулзалтын талаар тэмдэглэжээ. Ноот бичигт тэмдэглэснээр, Мак Артур сайд Юү Тэ Ха сайдад “...Америкийн тал шууд хамааралтай бус асуудалд хөндлөнгөөс оролцох бодол байхгүй” хэмээн онцлон дурдаад, “...тохиролцоонд хүрэх нь танай хоёр улсад л ялалт авчирна, гагцхүү коммунистуудын зорилго болсон Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрт цэг тавихаас зайлсхийх хэрэгтэй” гэж хэлжээ.

Мак Артур элчин сайдын онцлон дурдсан солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх АНУ-ын үл оролцох байр суурийг 1959 оны 2 дугаар сарын 12-ны өдөр, АНУ-ын Төрийн Департментын нарийн бичгийн даргын орлогч Дуглас Диллоноос БНСУ дахь ДТГ-таа илгээсэн заавар<sup>81</sup> дахин нотолж байгаа юм. Уг зааварт Өмнөд Солонгосын өндөр албан тушаалтнуудад уг асуудлаас үүдэн гарч болзошгүй аливаа нөхцөл байдалд хүлээцтэй байхыг сануулахыг зааварчлахын зэрэгцээ Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалд оролцох юм уу, эсэргүүцэх боломжгүй учир шалтгаанаа чөлөөт сонголтын эрхийн зарчмыг дэмжих нь Америкийн бодлоготой холбоотой гэж онцлон тэмдэглээд АНУ-д оршин сууж буй хятад иргэдийг Хятадын эх газар руу илгээх асуудалд оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчмыг баримталсан жишээг дурджээ.

1959 оны 2 дугаар сарын 13-ны өдөр, Японы засгийн газар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг Сайд нарын танхимаараа хэлэлцэн батлав. Тэр өдрийн маргааш АНУ-ын Төрийн Департментын байранд АНУ дахь БНСУ-ын ДТГ-ын

---

... I spoke to the Prime Minister today about the crisis in Japan-ROK relations and asked him where matters stood. He indicated that the Japanese Government felt obliged to go ahead with the proposal to repatriate those Koreans who wished to return to North Korea.

I said I understood the Koreans would break off relations if Japan proceeded with such a repatriation plan. The Prime Minister said he hoped they would not do so...

<sup>80</sup> MacArthur 주일 미대사가 주한 미대사관으로 보낸 전문. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-11, pp. 13-14.

... Yiu asked my views... I emphasised that US was very concerned to avoid a rupture, which could benefit only for communists but we could not intervene in sensitive dispute to which US not party. I hoped most earnestly agreement would prevail on both ROK and Japanese sides and a break would be avoided it would only serve communist purpose.

<sup>81</sup> Dillon 미 국무차관의 주한 미대사관으로 지시. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-12, pp. 16-17

Embassy instructed urge moderation at high level ROKG employing following arguments:

... (2) It is U.S. policy and practice to support principle of voluntary repatriation as evidenced by our permitting return of Chinese in this country to Communist Mainland. ...

удирдлагууд зорин ирж, Төрийн Департментын зөвлөх Вольтер Робертсонтой Япон, Өмнөд Солонгосын харилцааны тулгамдсан асуудлаар зөвшилцсөн байна. Тэрхүү уулзалтын үеэр АНУ дахь БНСУ-ын элчин сайд Ян Юү Чан “... Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх нь үнэн хэрэгтээ Умард Солонгосын улс төрийн эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Өмнөд Солонгос нь Япон дахь солонгос иргэдийг Өмнөдөд хүлээн авах хүсэл сонирхол байгаа ч юуны өмнө Японы Засгийн газар тус улс дахь солонгос иргэдэд олгох нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх ёстой” хэмээн уг асуудлыг эрс эсэргүүцэж байгаагаа тодорхой илэрхийлжээ.<sup>82</sup> Үүний хариуд Вольтер Робертсон “.. чөлөөт ертөнцийн хоёр улс болох Япон, Өмнөд Солонгосын харилцаа улам бүр дордож байгаад санаа зовниж байна. Тэр тусмаа энэ цаг үед Япон ийм үйл ажиллагаа явуулж буйд харамсаж байгаа хэдий ч манай улс Солонгосын дайны дараа Хятадын коммунистуудад чөлөөт сонголт хийх боломж олгосны нэгэн адил сайн дурын үндсэн дээр илгээхийг дэмжиж байгаа” гээд “Япон, Өмнөд Солонгос хоорондын асуудлыг хоёр улс гадны оролцоогүй (without outside intervention) шийдвэрлэх ёстой”<sup>83</sup> хэмээн санал бодлоо илэрхийлсэн байна.

Хэд хоногийн дараа буюу 2 дугаар сарын 19-ний өдөр, АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Кристиан Хертер (Christian A. Herter) солонгос иргэдийг Умард руу илгээх тухай асуудлаарх АНУ-ын албан ёсны байр суурийг холбогдох элчин сайдын яамдад мэдэгдсэн байна. Тэрээр “Япон Өмнөд Солонгосын хоорондын маргаантай асуудал нь холбогдогч талуудын хүрээнд гадны оролцоогүйгээр шийдэгдэх ёстой” гээд “АНУ-ын Төрийн Департмент нь ОУУЗН-ын ОУЗ-ийг солонгос иргэдийг сайн дурын үндсэн дээр илгээх хөтөлбөрт оролцохгүй байхыг ятгаж өгөхийг хүссэн БНСУ-ын Засгийн Газрын хүсэлтийг хүлээж авах боломжгүй” хэмээн байр сууриа дахин нотолсон байна. Мөн түүнчлэн ашиггүй, утга учиргүй гэж үзвэл Өмнөд Солонгосын хүсэлт шаардлагуудад хариулт өгөхөөс зайлсхийх нь зохистой хэмээн дурджээ.<sup>84</sup>

АНУ-ын Төрийн Департментын зүгээс солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаар албан ёсны байр сууриа ийнхүү илэрхийлснээс хойш 3 дугаар сар хүртэл уг асуудлаар Өмнөд Солонгос дахь дипломат төлөөлөгчийн газартайгаа албан бичиг солилцсонгүй. 3 дугаар сарын 6-ны өдөр, Ян Юү Чан элчин сайд, Вольтер Робертсон зөвлөх, Төрийн Департментын Зүүн Азийн Газрын дарга Грахам Парсонс нарын холбогдох албан тушаалтнуудын хурлын тэмдэглэл Өмнөд

<sup>82</sup> 미 국무차관, 한일 위기에 대하여 주미 한국공사와 Robertson 차관의 대화 요지를 주한미대사관에 전달. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-14, p. 24-25

<sup>83</sup> Dillon 미 국무차관이 주한 미 대사관에 보낸 주미 한국공사와 로베르튼 차관의 대화 요지. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-14, pp. 24-25

Mr. Robertson made following principal points:

... U.S. deeply disturbed by ROK statement of possible use of force to impede fulfillment Japanese plan; such action by ROK would bring condemnation free world; ... U.S. had believed basic problems of Koreans and Japan as one to be resolved between the two parties without outside intervention...

<sup>84</sup> Herter 국무장관 대리 재일한인 문제와 관련 국무부의 입장을 전달., 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-10, p. 47.

... In view United States position that ROK-GOJ dispute this issue is one to be resolved by parties involved without outside intervention, Dept cannot accede to ROK request that Dept attempt dissuade ICRC from complying with Japanese request to aid in voluntary repatriation plan. Embassy should however endeavor avoid replying directly to ROK request unless it feels compelled under circumstances or sees prospect some positive benefit.

Солонгос дахь ЭСЯ-нд ирэв. Тус хурлын тэмдэглэлээс үзвэл<sup>85</sup>, солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг тойрсон Япон, Өмнөд Солонгосын хоорондын хурцадмал байдалд Америкийн оролцоог хүссэн Ян Юү Чан сайдын хүсэлтэнд “... АНУ нь оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчмыг эсэргүүцэх аргагүй тул танай хоёр улсын аль нэг талын байр суурийг дэмжих боломжгүй” хэмээн Төрийн Департментын байр суурийг дахин нотолсон байна.

Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал хөндөгдөж эхэлсэн эхний үед АНУ-ын Төрийн Департментын зүгээс хүмүүнлэгийн зарчим оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хүндэтгэн үзэх нэрийдлээр үл оролцох байр суурийг баримталж байсан нь үнэн хэрэгтээ Зүүн Ази дахь Япон төвт гадаад бодлогынхоо хүрээнд, чөлөөт ертөнцийн ашиг сонирхолд үл нийцэх Японы бодлогыг буруушааж чадахгүй байв. Аль нэг талыг дэмжихгүй, асуудалд хөндлөнгөөс оролцохгүй хэмээн байр сууриа илэрхийлж, Өмнөд Солонгосын талд ихэд хөндий хандаж байсан болно.

Харин БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ-ны хувьд арай өөр байр суурь баримталж, энэ асуудалд харьцангуй уян хатан байдалтай хандаж байсныг тухайн үед элчин сайдаар ажиллаж байсан Вальтер Даулины үйл ажиллагааны талаар тэмдэглэсэн албан бичгүүдээс харж болно. Тухайлбал, 1 дүгээр сарын 17-ны өдөр Япон улсад суугаа элчин зөвлөх Чүэ Гюү Ха элчин сайд Вальтер Дуалинтай 50 минут орчим утсаар ярьсан тухайгаа төвдөө мэдээлсэн байна. Энэ нь Японы Гадаад хэргийн сайд Фүжияма солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрөө зарласны дараа 1959 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНСУ-ын Засгийн газар энэ асуудлаар эрс эсэргүүцсэн байр суурь илэрхийлэхээс өмнө болсон хэрэг юм. Ярианы тэмдэглэлийн гол агуулгыг нь товчхон авч үзвэл<sup>86</sup>, Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг эсэргүүцэж байгаа бөгөөд энэ асуудлыг аль болох газар авахуулахгүй байхыг хүсэж байгаагаа илэрхийлжээ. Элчин сайд Даулин “ОУУЗН оролцохоо мэдэгдэх юм бол Өмнөд Солонгосын Засгийн газар үүнийг зогсоох аргагүйд хүрнэ. Үнэнийг хэлэхэд ОУУЗН оролцоог нэмэгдүүлэх нь танайд ашигтай тул Япон Өмнөд Солонгосын хооронд ОУУЗН-ийн зүгээс энэ хөтөлбөрт хяналт тавих талаар тохиролцоо хийх хэрэгтэй” гээд танай зүгээс Японы Гадаад Хэргийн сайдтай уулзаж, ОУУЗН-ийн бүх талын оролцоог Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээр дээр ярилцаж тохиролцохоор зохицуулах хэрэгтэй гэж зөвлөжээ. Америкийн тал энэ асуудлаар хоёр улсын хооронд зуучилж, солонгос иргэдийг Өмнөд Солонгос руу илгээх арга замыг эрэлхийлэх, цаашлаад Япон дахь солонгос иргэдийн нөхөн төлбөрийн асуудлыг оруулах санаатай байгаагаа

<sup>85</sup> 제일한인 복송문제에 관한 양유찬 주미 한국대사와 국무부 관계자 회의 비망록, 국가편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-03-05, pp. 86-89.

... Mr. Robertson responded that we are deeply concerned that difficulties such as the repatriation issue should break open between two free world countries. ... Robertson continued that we let Chinese in the United States go to the Chinese mainland voluntarily. In other words, we use no force with regard to their repatriation... Mr. Robertson responded that the United States has been careful not to take sides. However, both Korea and Japan are allies of the U.S... He continued deeply disappointed at the disruption of talks between Japan and ROK.

<sup>86</sup> 제일한인 복송문제의 관련하여 다울링 미 대사와 가진 전화통화내용 보고, 공한 (MTB-021), 1959-1-31, 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0037-0039, 영어

илэрхийлжээ. Хэлэлцээр дахин эхлэх үед Япон дахь солонгос иргэдийн хууль эрх зүйн статусын асуудлыг нэг мөр шийдвэрлэх ёстойг анхааралдаа авч, хүсэл зориг, чөлөөт сонголтын үндсэн дээр илгээх тал дээр Өмнөд Солонгосын Засгийн газрын зүгээс үндсэн зарчим болоод бодит үр дүнгийн талаар шүүмжилж, буруушаахаас зайлсхийх хэрэгтэйг сануулсан байна. Өмнөд Солонгосын Засгийн газрын хувьд иргэдийг Умард руу илгээх асуудлыг эсэргүүцэж, энэ асуудлыг аль болох газар авахуулахыг хүсэхгүй байгаагаа илэрхийлсэн элчин сайдын санал бодол нэгэн улсыг төлөөлөх өндөр албан тушаалын дипломат ажилтан гэдэг утгаараа маш чухал ач холбогдолтой байсан нь гарцаагүй юм. Тиймээс ч БНСУ-ын Засгийн газар энэ асуудлаар эрс хатуу байр суурийг итгэлтэйгээр илэрхийлсэн биз ээ.

АНУ-ын ЭСЯ-ны элчин зөвлөх Сэм Жильстрапын төвдөө илгээсэн 2 дугаар сарын 2-ны өдрийн мэдээнээс үзвэл<sup>87</sup>, "... Японы Гадаад хэргийн сайд Фүжиямагийн хийсэн мэдэгдлээс хойш Өмнөд Солонгосын хэвлэлүүдэд гарсан БНСУ-ын Засгийн газрын мэдэгдлүүд Япон, Өмнөд Солонгос хоёр улсын зөрчил, хагаралыг улам бүр гүнзгийрснийг харуулж байна" гээд "Хэрэв Япон солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх юм бол Япон, Өмнөд Солонгосын харилцааг сайжруулах хэлэлцээр тодорхойгүй болно гэхээс ЭСЯ-ны зүгээс ихэд санаа зовниж байна" гэжээ. Япон, Өмнөд Солонгос хоёр улсын харилцаа улам бүр дордож, хурцадмал байдалд орж байгаагийн шалтгаан нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал гэдгийг Элчин сайдын яамныхан сайн ойлгож байсан бөгөөд үүнд Төрийн Департментын зүгээс нааштай байр суурь барьж, заавар зөвлөмж өгөх шаардлагатай гэсэн утгыг уг албан бичиг агуулж байгаа юм.

Элчин сайд Вальтер Даулин уг асуудлыг зөв оновчтой шийдвэрлэх хэрэгтэй бөгөөд гол нь Японтой хийх хэлэлцээрийг хойшлуулалгүй дахин эхлүүлэх шаардлагатай гэж үзэж байлаа.<sup>88</sup>

**Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал хөндөгдөж эхэлсэн үеийн уг асуудлаарх АНУ-ын байр суурийг нэгтгэн дүгнэж үзвэл**, юуны өмнө, АНУ-ын Төрийн Департмент нь уг асуудлыг объектив өнцгөөс ойлгож, асуудалд хөндлөнгөөс оролцохгүй гэсэн байр суурин дээр хатуу зогсож байсан. Тэдний хувьд АНУ-ын Зүүн Ази дахь бодлого, Япон төвт стратеги төлөвлөгөөнд Япон, Өмнөд Солонгосын харилцааг хэвийн болгох явдал нэн чухал тул энэхүү асуудлаас үүдэн гарч болзошгүй хурцадмал байдалд санаа зовниж байлаа. Тиймээс ч хоёр улсын хооронд үүссэн маргаантай асуудалд аль нэг талыг дэмжихгүй хэмээн байр сууриа илэрхийлж байв. Гэсэн хэдий ч бодлогын хүрээнд Японыг чухалчлан үзэх тул Япон дахь ДТГ-аараа дамжуулан уг асуудлаар дипломат ажиллагаа идэвхтэй явуулж байсан бол Өмнөд Солонгосын идэвхтэй дипломат ажиллагаа, хүсэлт шаардлагад

<sup>87</sup> Gilstrap, 일본정부의 제일한인 자원 북송 결정과 관련된 한국 언론의 보도 경향을 국무장관에게 보고, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-02, pp. 5-6

... Embassy believes real possibility ROK would break off talks if Japanese implement idea repatriation to North Korea. If ROKG takes this action would be with support most element Korean society and chances settlement foreseeable future would be seriously jeopardized.

<sup>88</sup> Dowling, 한일회담 재개를 위해 한국정부에 압력을 행사해야 한다는 입장, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-28, pp. 67-68.

тун идэвхгүй, хайнга хандаж байлаа. Японы холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцах үедээ ихэд болгоомжтой хандаж, ярилцаж зөвшилцөлгүй шийдсэн тэдний үйлдлийг шүүмжилж, буруушаасан байдал гаргасангүй. Гагцхүү коммунист лагерийнхны арга мэх гэдэг утгаар нь анхааруулах юм уу санаа зовсон хандлага үзүүлж байсан юм. Харин Өмнөд Солонгосын тухайд, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх, хүмүүнлэгийн зарчим, асуудалд хөндлөнгөөс оролцохгүй гэсэн байр сууриар түрүү барьж тэдний тавьсан хүсэлт шаардлагад татгалзах, зайлсхийх байдал үзүүлсэн төдийгүй уг асуудлаар баримталсан тэдний хатуу байр суурь, эрс эсэргүүцлийг шүүмжлэх хандлага үзүүлж байсан нь ажиглагдсан юм.

Төрийн Департментын байр сууринаас ялгаатай нь БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ-ны байр суурь харьцангуй идэвхтэй, нааштай хандлагатай байсныг элчин сайд Дуглас Даулины үйл ажиллагаа харуулж байсан гэхэд болно. Элчин сайдын яам АНУ-ын Зүүн Ази дахь Япон төвт шинэ бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн төлөөх Америкийн ашиг сонирхлыг харгалзан үзэх, солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаас шалтгаалан үүсэн гарах улс төрийн гадаад, дотоод тогтворгүй байдал зэрэг суугаа улсынхаа ашиг сонирхлыг бодолцож үзэх үүднээс Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээх хоёр талын уулзалт хэлэлцээрийг дахин эхлүүлэхийг гол зорилтоо болгож байв. Тиймээс уг маргаант асуудал хойш сунжрах тусам ашиггүй гэж үзээд БНСУ-ын Засгийн газрын зорьж буй солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоож чадахгүй юм аа гэхэд асуудлыг газар авахуулахгүй байхад хичээл зүтгэх гаргах оролдлого хийж байсан юм. Үүний тулд, нэгэнт уг хөтөлбөрийг зогсооход бэрхшээлтэй болсон учир үй олноор нь умард руу илгээхийг багасгахын тулд ОУУЗН-ийн оролцоог дэмжих, Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлэх замаар хоёр улсын хооронд тодорхой хэлэлцээ тохиролцоонд хүрэх зэрэг оновчтой арга замуудыг зөвлөх, ятгах зэрэг арга хэмжээг идэвхтэй явуулсан юм. Энэхүү асуудлаарх ОУУЗН-ийн оролцоог дэмжих, Япон, Өмнөд Солонгосын харилцааны хурцадмал байдлыг намжаан зөөлрүүлэхэд зуучлах зэргээр Америкийн оролцоо чухал гэдгийг Төрийн Департментад ойлгуулж таниулахад гүйцэтгэсэн БНСУ дахь ДТГ-ын хүчин зүтгэлийг онцлон дурдууштай. Товчоор хэлбэл, 1959 оны эхэн үе, солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал хөндөгдөж эхлэх үед АНУ-ын Төрийн Департмент уг асуудлыг Япон, Өмнөд Солонгос хоёр талын харилцан шийдвэрлэх асуудал гэсэн байр суурьтай байсан бол БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ уг асуудалд Америкийн идэвхтэй оролцоо хэрэгтэй гэдгийг ойлгож, суугаа орныхоо тавьж буй хүсэл шаардлагад дэмжлэг үзүүлэх байр суурьтай хандаж байсан юм.

Хэдийгээр АНУ үл оролцох байр суурь баримталж байсан ч уг асуудлаар үргэлжид санаа зовниж байсныг дурдсан. 1 дүгээр сарын 30-ны өдрийн Японы ерөнхий сайдын мэдэгдлийн дараа солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг коммунист лагерийнхны нөлөөгөө тэлэх бодлогын нэг хэсэг гэж ойлгож байсан Америкийн тал 2 дугаар сарын 13-ны өдөр, Японы Сайд нарын танхим уг хөтөлбөрийг баталснаас хойш улам бүр санаа зовох болсон. Яваандаа солонгос

иргэдийг Умард руу илгээх асуудалд Америк оролцохоос өөр аргагүй байдалд хүрч, юуны өмнө уг хөтөлбөрт ОУУЗН-ийг оролцуулах шаардлагатай гэсэн шийдвэрт хүрсэн байна. Нөгөө талаар Өмнөд, Хойд Вьетнам, Тайландын цагаач иргэдийг шилжүүлэх асуудалд солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал сөрөг нөлөө үзүүлэх вий хэмээн ОУУЗН-ийн оролцоог зайлшгүй гэж үзсэн хэрэг. Ингээд 3 дугаар сарын 18-ны өдөр, АНУ-ын Төрийн Департамент (ТД) холбогдох Дипломат Төлөөлөгчийн Газруудаараа дамжуулан ОУУЗН-ийг гадна орхисон Япон, Умард Солонгосын УЗН хоорондын хэлэлцээрийг эсэргүүцэж байр сууриа илэрхийлэв.<sup>89</sup> Японд суугаа элчин сайд Мак Артур солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийн хяналт шалгалтын хэсэгт ОУУЗН-ийг оролцуулахгүй байхыг хүссэн Умард Солонгосын УЗН-ийн байр суурийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Японы Гадаад Хэргийн Яамны хичээл зүтгэл талаар болохыг онцлон сануулсан албан бичгийг Японы Засгийн Газарт илгээжээ.<sup>90</sup> Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрт ОУУЗН-ийн оролцуулахаар шахалт үзүүлсэн бодлого тасралтгүй явуулсан боловч, 1959 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр, Женев хотноо Япон, Умард Солонгосын УЗН хоорондын хэлэлцээр нээгдсэн юм.

### **Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх асуудал шийдэгдэх үйл явц ба АНУ-ын идэвхтэй оролцоо**

Япон дахь солонгос иргэдийг умард руу илгээх асуудал шийдэгдэх үе буюу 1959 оны дунд үед хамаарах АНУ-ын ТД болон БНСУ-д суугаа ДТГ хооронд солилцсон Өмнөд Солонгос болон уг асуудалд холбогдох бичиг баримт харьцангуй нэмэгдсэн нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаарх Америкийн оролцоо нилээн идэвхжсэн болохыг харуулж байна.

АНУ солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрт ОУУЗН-ийг хянах үүрэгтэйгээр оролцуулах замаар дам байдлаар асуудалд оролцохоор төлөвлөж байсан боловч 3 сарын турш ямар ч ахиц гарсангүй. Япон хөтөлбөрт ОУУЗН-ийг оролцуулах тал дээр баттай байр сууринд зогсож чадаагүй бол Умард Солонгос зогсолтгүй эсэргүүцсээр байсан юм. Өмнөд Солонгосын хувьд, Япон, Умард Солонгосын хэлэлцээр зогсох хүртэл Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээр дахин эхлэх асуудал байхгүй хэмээн байр сууриа илэрхийллээ (강여린, 2013; 81). Женевийн хэлэлцээр тохиролцоонд хүрч, удахгүй ОУУЗН-ийн ОУХороонд оруулах талаар яригдаж эхэлмэгц солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрийг хянах боломжгүй болсон АНУ, Япон болон Умард Солонгостой хамтран хэрэгжүүлэх энэ ажил Зүүн Азийн энх тайван, чөлөөт лагерийнханд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзээд уг асуудалд илүү идэвхтэй оролцохоор шийдсэнээ ийн илэрхийлжээ.

“... Бид Япон, Өмнөд Солонгосын хоорондын зөрчилд үл оролцох байр суурь баримталж ирсэн боловч энд өрнөөд байгаа эмгэнэлт нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд АНУ-ын Засгийн Газар оролцох цаг ирсэн эсэхийг бодолцож үзэх хэрэгтэй байна”<sup>91</sup>

<sup>89</sup> 미 국무부에서 방콕, 사이공, 도쿄, 서울 등으로 보낸 전문, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 1959-03-18, pp. 109.

<sup>90</sup> MacArthur 주일 미대사가 보낸 전문, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 1959-03-18, pp. 106.

<sup>91</sup> Dillon, 미 국무부 북일적십자사 회담 터결과 북송개시가 한국의 방해활동을 유발할 것을 강조한 전문, 국사편찬위원회,

Хожимдсон хэдий ч, Япон, Умард Солонгосын УЗН хоорондын Женевийн хэлэлцээрийн төслийг албан ёсоор ОУУЗН-ийн ОУХороонд өргөн барьсны дараа сая АНУ болон Өмнөд Солонгосын Умард руу илгээхийг зогсоох хариу арга хэмжээ эхэлсэн юм. 1959 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, БНСУ-ын Засгийн Газар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлын зүй бус байдлыг заасан 16 зүйлт эсэргүүцлийн бичиг үйлдэн, байр сууриа илэрхийллээ.<sup>92</sup> Уг бичгийн агуулгыг товчхон дурдвал, солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал нь зүгээр нэг гадаад иргэдийг хөөн гаргах асуудал биш хоёр улсын харилцааны нэн чухал асуудал учир Япон Өмнөд Солонгосын хэлэлцээрээр, хоёр улсын улс төрийн асуудлын хүрээнд шийдэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлжээ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдсэн нь Өмнөд Солонгостой яриа хэлэлцээр хийхээс ухарч, коммунистуудтай наймаалцаж байгаа явдал хэмээн буруушаагаад уг асуудлыг анхнаасаа Японы Гадаад Явдлын Яам, Хууль Зүйн Яамны албаны хүмүүс эхлүүлсэн тул ОУУЗН-ийн гаргаж тавьсан хүмүүнлэгийн зарчим Японы Засгийн газрын мөн чанарыг нууцлах арга хэрэгслээс цаашгүй хэмээн шүүмжилсэн байна. Гал зогсоох хэлэлцээрээр хоригдлуудыг нутаг буцаах үед чөлөөт сонголтыг үл ойшоон, социалист орон руу илгээхийг хориглож байсан хэрнээ оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчим гэх сайхан нэрийн дор энгийн номхон иргэдийг ямар ч эрх чөлөөгүй коммунизмын удирдлага дор түлхэн оруулах нь зүйд үл нийцнэ гэжээ. Түүнчлэн Умард руу илгээх нь Умард Солонгосын зэвсэгт хүчнийг бэхжүүлэн улмаар чөлөөт лагерийн аюулгүй байдалд аюул занал учруулж байгаа хэрэг гээд Японы солонгос иргэдийг нутгаасаа хөөн зайлуулах төлөвлөгөө нь БНСУ-ын бүрэн эрхийг үгүйсгэн, Умард Солонгосыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг гэж үзсэн байна.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Кристиан Гертер БНСУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ким Дун Жүгийн Япон дахь солонгос иргэдийг өмнөд Солонгос руу шилжүүлэхийг санал болгосон “бүтээлч хөтөлбөр (positive program)”-ийг Умард руу илгээх асуудлыг шийдвэрлэхэд бүтээлч арга зам болно хэмээн дүгнээд дахин нягталж, шалгах үүрэг өглөө.<sup>93</sup> Хэд хоногийн дараа БНСУ-ын Засгийн газраар батлуулж, И Сын Ман ерөнхийлөгчөөр хүлээн зөвшөөрүүлэхээр ятгахыг Сөүл дэх ЭСЯ-ндаа зааварлав.<sup>94</sup>

Япон дахь АНУ-ын ЭСЯ-ны зүгээс БНСУ-ын Засгийн Газар “бүтээлч хөтөлбөр”-ийг баталж, солонгос иргэдийг Өмнөд Солонгост дахин суурьшин амьдрахад нь идэвхтэйгээр дэмжихээ илэрхийлэх юм бол Өмнөд Солонгос руу эргэж ирэх

한일회담 관계 미 국무부문서 6 (1959), 주일 미국 대사관 문서철. 1959-06-27, pp. 204.

... While we always preferred not to become directly involved in GOJ-ROK deifferences, we are wondering whether time has not come for US Government to intervent in order endeavor head of potentially tragic situation now developing. We are therefore considering whether it might not be advisable to move now rather than later when crisis more explosive and to take dramatic step in effort achieve basis COJ-ROK rapprochement. ...

<sup>92</sup> 제일한인 복송의 경위와 이의 부당성을 지적하며 한국정부의 입장을 16항목으로 정리한 문서. 1959-7-1; 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0055-0061, 한국어

<sup>93</sup> Herter 국무장관이 김도조 외무차관의 건설횐인 프로그램을 재확인 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-02, pp. 308.

<sup>94</sup> Murphy 국무부 정부부차관이 김도조 외무차관의 건설횐인 프로그램을 이승만 대통령이 승인하도록 설득하는 것을 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-06, pp. 326.

солонгос иргэдийн тоог багцаагаар гаргаж болно<sup>95</sup> гэж төвдөө тайлагнаж байжээ. Ийм маягаар Америкийн тал Умард руу илгээх хөтөлбөрийн Умард руу чиглэсэн хүрээг хумих, Өмнөд рүү ойртуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байв.

Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх ажиллагааг бодит үнэн хэмээн хүлээн зөвшөөрч, цаашид үүсэж болох нөхцөл байдал хийгээд түүнд тохирох арга замыг эрэлхийлж эхлэв. Тухайлбал, ОУУЗН-ээс Япон, Умард Солонгосын хэлэлцээрийг зөвшөөрөх болон эс зөвшөөрөх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох заавар элчин сайдын яамдуудад өгчээ.<sup>96</sup> Үүнийг өргөн утгаар нь солонгос иргэдийг Умард руу илгээх хөтөлбөрөөс шалтгаалан улам дордсон Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээж, сайжруулахын тулд авч явуулсан Америкийн хөндлөнгөөс оролцох бодлого гэж үзэж ч болох юм. Ямартаа ч Америкийн боловсруулсан сөргүүлэн тавих бодлогод ОУУЗН-ийг Умард руу илгээх хөтөлбөрт оролцуулах, Япон дахь солонгос иргэдийн Умард руу чиглэсэн хүрээг хумих тал дээр гол анхаарлаа хандуулж байв.

7 дугаар сарын 9-ний өдөр, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Гертер И Сын Ман ерөнхийлөгчөөр оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчмыг хүлээн зөвшөөрүүлэх даалгавар<sup>97</sup> өгсний дагуу элчин сайд Даулин И Сын Ман ерөнхийлөгчтэй хэд хэдэн удаа уулзаж, Умард руу илгээх асуудлаар санал солилцон, зөвлөлдсөн боловч тодорхой үр дүнд хүрч чадаагүй тухайгаа “... Япон дахь солонгос иргэдийг коммунизмын үүр уурхай руу яасан ч явуулж чадахгүй гэсэн түүний үгийг сонсоод түүнтэй энэ асуудлаар дахин хэлэлцээд ямар ч нэмэргүй гэдгийг ойлгосон”<sup>98</sup> гэж төвдөө мэдээлжээ. И Сын Ман ерөнхийлөгчтэй хэд хэдэн удаа уулзсан авч ятгаж дийлээгүй тэрээр 7 дугаар 17-ны өдөр Гадаад хэргийн дэд сайд Ким Дун Жүтэй уулзаж үүсэн бий болсон тэрээр нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналаа бичсэн албан бичгийг гардуулжээ.<sup>99</sup> Тэрхүү бичгийн агуулгыг нягталж үзвэл, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн зарчмыг хүлээн зөвшөөрөх нь солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоох хамгийн зөв сонголт бөгөөд хэрвээ Өмнөд Солонгосын тал Засгийн газрын хувьд ч, ард иргэдийн түвшинд ч эсэргүүцлээ үргэлжлүүлсээр байх юм бол Япон дахь солонгос иргэдийн ихэнх нь Умард Солонгосыг сонгох болно. Иймд энэхүү зарчмыг хүлээн зөвшөөрч, Өмнөд Солонгосыг сонгосон иргэдийг татах, хүлээн авах боломжийг бүрдүүлэхийн тулд нэн даруй Япон

<sup>95</sup> Mac Arthur 주일 미국대사 국무장관에게 보낸 전문, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 6 (1959), 주일 미국 대사관 문서철. 1959-07-15, pp. 358.

<sup>96</sup> Herter 국무장관의 미국의 대응정책, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 6 (1959), 주일 미국 대사관 문서철. 1959-07-9, pp. 329-330.

<sup>97</sup> Herter 국문장관 이승만 대통령 자유선택의 원칙을 받아들이도록 설득할 것을 다울링에게 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-09, pp. 349.

<sup>98</sup> Dowling 주한대사와 이승만대통령과의 논의, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-10, pp. 354-355.

Tonight Vice Minister of Foreign Affairs told me President Rhee has asked him inform me that because of “national spirit” ROKG could not rpt not accept principle which would condone Koreans going to communist territory. I reviewed with Vice Minister futility of present ROKG position, and told him I would undoubtedly be instruted discuss issue futher with Rhee...

<sup>99</sup> Dowling 대사와 김동주 외무차관과의 회합. 1959-7-17; 분류번호: 723 JA 북 1955-60 V2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0064-0067, 영어

Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлэх нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг зогсоох, асуудлыг нааштай шийдвэрлэх цорын ганц арга зам гэжээ. Өмнөд Солонгосын талаас Японы Засгийн Газартай солонгос иргэдэд олгох нөхөн төлбөрийн асуудлыг голлон солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлаар хэлэлцээр эхлүүлэхэд тусалж өгөхийг АНУ-ын Засгийн Газраас хүссэн хүсэлт гаргах хэрэгтэй гэж зөвлөжээ. Японы талаас нөхөн төлбөр авахад бид тусалж болох бөгөөд хэрвээ энэ боломжийг алдах юм бол Төрийн Департментын зүгээс энэ асуудалд өөрөөр тусламж үзүүлэх боломжгүй хэмээн сануулсан байна.<sup>100</sup>

Судлаач И Хён Жин Америкийн тал тасрахад хүрсэн Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин үргэлжлүүлэхийн тулд зуучлагчаар оролцсон нь хоёр улсын дараа дараагийн асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болж өгсөн (이현진, 2010; 88) хэмээн үнэлсэн бол Кан Ё Рин асуудал шийдэгдэх үеийн Америкийн оролцоог дүгнэхдээ Америкийн тал хэдийгээр идэвхтэй байсан ч Өмнөд Солонгосын тавьсан нөхцлүүдийг хангах боломжгүй учир уг асуудлаар зуучлалын дипломат ажиллагаа (good offices) явуулж чадаагүй (강여린, 2013; 95) гэж үзжээ.

Ийнхүү элчин сайд Вольтер Даулины зөвлөмжийн дагуу, БНСУ-ын Засгийн Газар аман мэдэгдэл хийж, 24-ний өдөр элчин сайдад гардууллаа. Уг аман мэдэгдэлд<sup>101</sup> Японд байгаа 600 мянган солонгос иргэдийг шилжүүлэх асуудлаар Японы Засгийн газартай хэлэлцээ хийхийг эрмэлзэж байгаагаа илэрхийлээд Японы Засгийн Газар Япон дахь солонгос иргэдэд нөхөн төлбөр олгож, тэдний эд хөрөнгийг хязгаарлалтгүйгээр тээвэрлэж өгөхөө амлах юм бол Өмнөд Солонгосын зүгээс тэдний бөөнөөр илгээх хөтөлбөрийг хүлээн авахад бэлэн байгаагаа илэрхийлээд, АНУ-ын засгийн газарт хоёр улсын харилцаанд зуучилж өгөхийг хүсчээ.

Мөн сарын 29-ний өдөр Японд суугаа БНСУ-ын Элчин сайд Юү Тэ Ха Японы Гадаад хэргийн сайд Фүжияма Айичиротой уулзан хоёр улсын харилцаа улам бүр дордохыг хүсэхгүй байгаа тул Япон Өмнөд Солонгосын хэлэлцээрийг ямар нэг нөхцөл болзолгүйгээр дахин эхлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.<sup>102</sup> Хоёр талын хэлэлцээрийг ямар ч болзолгүй эхлүүлсний гол зорилго нь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг хоёр орны харилцааны хүрээнд шийдвэрлэхэд чиглүүлэхэд оршиж байсныг хэлэлцээрт оролцсон Өмнөд Солонгосын төлөөлөгчдийн 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлын протоколоос<sup>103</sup> харж болно. Гадаад хэргийн дэд сайд Ким Дун Жү “.. ний нуугүй хэлэхэд энэ удаагийн хэлэлцээрийг Умард руу илгээх асуудлыг эсэргүүцэхийн төлөө л явуулж байгаа учраас Япон дахь солонгос иргэдийн асуудлыг юун түрүүн хэлэлцэх ёстой” хэмээн хэлж байжээ.

<sup>100</sup> Dowling 대사의 외무차관에게 전한 의견서. 1959-7-21; 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0070-0072, 영어

<sup>101</sup> 재일한인 북송문제에 한국 측 구두성명. 1959-7-21; 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0074-0075, 영어

<sup>102</sup> 재일한인 북송문제에 한국 측 구두성명. 1959-7-29; 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0127-0128, 영어

<sup>103</sup> 4차 한일회담 한국 대표단 사진 협의회 회의록. 1959-8-11; 분류번호: 723 JA 북 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0127-0128, 영어

8 дугаар сарын 12-ний өдөр, Япон Өмнөд Солонгосын 4 дэх удаагийн яриа хэлэлцээр Америкийн зуучлалаар дахин нээгдэж, Умард руу илгээх асуудлыг хэлэлцэхээр зэхэж байсан боловч, дараахь өдөр нь Энэтхэгийн Калькутта хотноо Японы УЗН болон Умард Солонгосын УЗН-ийн хооронд Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх тухай хэлэлцээр байгуулагдснаар солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоохыг оролдсон Өмнөд Солонгосын хичээл зүтгэл, түүний цар хүрээг багасгахын төлөөх Америкийн оролцоо талаар болж, уг асуудал Япон, Өмнөд Солонгосын уулзалт хэлэлцээрийн хэлэлцэх асуудлын жагсаалтаас бүрмөсөн хасагдсан болно.

*Солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал шийдэгдэх үеийн уг асуудлаарх АНУ-ын байр суурийг нэгтгэн дүгнэж үзвэл,*

Япон, Умард Солонгосын УЗН хоорондын Женевийн хэлэлцээр эхэлснээс хойш ОУУЗН-ийг хянах үүрэгтэйгээр оролцуулах замаар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалд дам байдлаар оролцохоор төлөвлөж байсан Төрийн Департментын санаархал боломжгүй болж, хөтөлбөр бодитоор хэрэгжих нь тодорхой болж эхэлмэгц Япон, Умард Солонгосын хамтран хэрэгжүүлэх энэ ажил чөлөөт лагерийнханд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзээд уг асуудалд шууд оролцох болсноо албан ёсоор мэдэгдэж, чиглэлийн холбогдох байгууллагуудад тодорхой бодлого, заавар өгч эхлэв. Нэгэнт шийдэгдсэн үнэн хэмээн хүлээн зөвшөөрсөн Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлын хүрээг хумих, үр дагаварыг багасгахад гол анхаарлаа хандуулж, Өмнөд Солонгосын бодлогод нөлөөлөх замаар оролцоогоо идэвхжүүлж, зуучлах бодлого боловсруулж эхэлсэн юм. Япон дахь солонгос иргэдийг Өмнөд Солонгос руу шилжүүлэхийг санал болгосон БНСУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ким Дун Жүгийн “бүтээлч төлөвлөгөө”-г Төрийн Департаментаас дэмжин, И Сын Ман ерөнхийлөгчид нөлөөлөхийг үүрэг болгож, Япон, Өмнөд Солонгосын харилцааг сайжруулах 4 дэхь удаагийн яриа хэлэлцээрийг дахин эхлүүлэхэд анхаарлаа хандуулж байв.

Төрийн Департментын хэрэгжүүлэгч байгууллага болох БНСУ-д суугаа ЭСЯ-ны хувьд юу юунаас илүү дордож муудсан Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээхэд бүх боломж бололцоогоо дайчлан ажилласан гэж үзэж болно. Элчин сайд Даулины хувьд Япон, Умард Солонгосын хэлэлцээр байгуулагдахаас өмнө Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлж чадвал, яриа хэлэлцээрээр дамжуулан солонгос иргэдийг Умард руу илгээх ажлын хүрээг хумиж, үр дагаварыг бууруулж чадна гэж найдан, ямар ч болзолгүйгээр 4 дэх удаагийн яриа хэлэлцээрийг эхлүүлэхэд зуучилж өгсөн юм. Гадаад хэргийн сайд Ким Дун Жүтэй удаа дараа уулзаж хэлэлцэн, түүний “бүтээлч төлөвлөгөө”-г Төрийн Департаментаар дэмжүүлэхэд хүчин зүтгэл гаргасан юм.

Гадаад харилцааны архив дахь дипломат бичиг баримт, эх сурвалжуудыг үндэслэн, Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээж, хэвийн байдалд оруулахад элчин сайд Дуглас Даулины хичээл зүтгэлийг үнэлж болох агаад, онолын талаас нь авч үзвэл уг асуудалд түүнийг нөлөө бүхий тоглогч байсан хэмээн үзэж байна.

Ялангуяа солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалд суугаа орныхоо байр сууринаас асуудалд уян хатан хандаж байсан түүний үүрэг роль, хувь нэмэр АНУ-ын баримталсан бодлого, байр суурь, оролцоонд шууд нөлөөлж байсныг нотолно.

АНУ-ын хожуу оролцоо, уг асуудлын үр дагаварыг багасгахыг оролдсон оролдлого амжилтанд хүрч чадаагүй хэдий ч асуудал шийдвэрлэгдэх үед АНУ-ын гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болоод хэрэгжүүлэгч байгууллагын байр суурь нэгдмэл байж, асуудалд идэвхтэй оролцох болсон нь юуны өмнө Зүүн Азийн бүс нутаг дахь АНУ-ын гадаад бодлогын гол тулгуур болсон Япон, Өмнөд Солонгосын харилцааны хурцадмал байдал, хоёрдугаарт, уг асуудлаас үүдэн гарч болзошгүй коммунизмын аюул занал, өөрөөр хэлбэл бүс нутгийн энхтайван, чөлөөт лагерийнхны эв нэгдэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлал, гуравдугаарт, БНСУ-д суугаа ДТГ-ын идэвхтэй үйл ажиллагаа, үүрэг рольтой шууд холбоотой гэж үзэж байна.

### ДҮГНЭЛТ

Умард Солонгосоос оргон зугатсан солонгос иргэдийн асуудал гэх зэргээр өнөөдрийг хүртэлх урт хугацааны үр дагавар дагуулсан Япон дахь солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал нь үндэстэн хоорондын сэтгэл зүйн зөрчилт байдлаас шалтгаалан дайны дараах Япон, Өмнөд Солонгосын харилцаа төдийгүй Америк, Өмнөд Солонгосын харилцаанд хурцадмал байдал үүсгэсэн ноцтой асуудал хэмээн үздэг. Япон, Умард Солонгостой хэлэлцэн тохиролцож, Японд амьдарч байсан солонгос иргэдийг Умард Солонгос руу бөөнөөр шилжүүлэх болсонтой холбоотой үүсэж гарсан энэ асуудлыг эрс эсэргүүцсэн БНСУ-ын хатуу байр суурь, уг хөтөлбөрийг таслан зогсоох гэсэн оролдлого, хожимдсон хэдий ч идэвхтэй оролцоогоор дамжуулан асуудлын цаг хүрээ, үр дагаварыг багасгаж хумихыг оролдсон АНУ-ын байр суурь, хичээл зүтгэл эцсийн дүндээ амжилтгүй болсон юм.

Энэхүү өгүүлэлд солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлыг сонгон авч, уг асуудлыг тойрсон гол тоглогчдын нэг болох АНУ-ын гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болох Төрийн Департамент, хэрэгжүүлэгч байгууллага болох БНСУ-д суугаа Элчин Сайдын Яамны уг асуудлаар баримталж байсан бодлого, байр суурийн ялгааг асуудал хөндөгдөж эхэлсэн үе болон шийдвэрлэгдэх үе гэсэн цаг хугацааны үечлэлээр судалж үзэхэд анхаарлаа хандуулсан болно.

Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу илгээх асуудлаарх АНУ-ын байр суурийг нэгтгэн дүгнэж үзвэл, асуудал хөндөгдөж эхэлсэн үе буюу 1959 оны эхэн үед Төрийн Департаментын зүгээс уг асуудлыг объектив өнцгөөс ойлгож, асуудалд хөндлөнгөөс оролцохгүй гэсэн байр суурь баримталж байв. Тэдний хувьд Зүүн Ази дахь Япон төвт бодлогынхоо хүрээнд Японыг чухалчлан үзэх тул уг асуудлаар Японы талтай ихэд болгоомжтой хандаж, өндөр албан тушаалтнуудтай удаа дараа уулзаж ярилцан, ихэд анхаарал тавьж байсан бол Өмнөд Солонгосын тухайд, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх, хүмүүнлэгийн зарчим, асуудалд

хөндлөнгөөс оролцохгүй гэсэн байр сууриар түрүү барьж тэдний тавьсан хүсэлт шаардлагад татгалзах, зайлсхийх зэргээр идэвхгүй, хайхрамжгүй хандаж, тэр бүү хэл уг асуудлаар баримталсан Өмнөдийн хатуу байр суурь, эрс эсэргүүцлийг шүүмжлэх хандлагатай байсан нь ажиглагдсан юм. Төрийн Департментын зүгээс Япон, Өмнөд Солонгосын хооронд үүссэн маргаантай асуудалд аль нэг талыг дэмжихгүй гэсэн байр суурь болоод энэхүү асуудлаас үүдэн гарч болзошгүй хоёр улсын харилцааны хурцадмал байдалд санаа зовниж байгаагаа удаа дараа илэрхийлж байсан ч үнэн хэрэгтээ хоёр улстай ийн ялгаатай харилцаж байсан нь уг асуудлаарх Өмнөд Солонгосын эсэргүүцлийг улам бүр дэврээж, Японтой төдийгүй АНУ-тай харилцах харилцаанд хурцадмал байдал үүсгэж байсан гэж үзэж болно.

Төрийн Департментын байр сууринаас ялгаатай нь БНСУ-д суугаа АНУ-ын ДТГ-ын байр суурь харьцангуй идэвхтэй, нааштай хандлагатай байсан юм. Элчин сайд Дуглас Даулин уг маргаант асуудал хойш сунжрах тусам ашиггүй гэж үзээд Өмнөд Солонгосыг зорьж буй солонгос иргэдийг Умард руу илгээхийг зогсоож чадахгүй юмаа гэхэд асуудлын үйлчлэх хүрээг багасгахын тулд ОУУЗН-ийн оролцоог дэмжих, Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлэх замаар хоёр улсын хооронд тохиролцоонд хүрэх зэрэг оновчтой арга замуудыг зөвлөх, ятгах зэрэг арга хэмжээг идэвхтэй явуулсан юм. Товчоор хэлэхэд солонгос иргэдийг Умард руу илгээх асуудал хөндөгдөж эхлэх үед АНУ-ын Төрийн Департмент уг асуудлыг Япон, Өмнөд Солонгос хоёр талын харилцан шийдвэрлэх асуудал гэсэн байр суурьтай байсан бол БНСУ-д суугаа АНУ-ын ЭСЯ уг асуудалд Америкийн идэвхтэй оролцоо хэрэгтэй гэдгийг ойлгож, суугаа орныхоо тавьж буй хүсэл шаардлагад дэмжлэг үзүүлэх байр суурьтай хандаж байсан юм. Харин асуудал шийдвэрлэгдэх үед буюу 1959 оны дунд үед АНУ-ын байр суурь эрс өөрчлөгдөж, идэвхтэй оролцох болсон юм. ОУУЗН-ийг хянах үүрэгтэйгээр оролцуулах замаар солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалд дам байдлаар оролцохоор төлөвлөж байсан Төрийн Департментын санаархал боломжгүй болж, хөтөлбөр бодитоор хэрэгжих нь шийдэгдсэн үнэн хэмээн хүлээн зөвшөөрсөн Америкийн тал солонгос иргэдийг Умард руу илгээх асуудлын хүрээг хумих, үр дагаварыг багасгахад гол анхаарлаа хандуулж, Өмнөд Солонгосын бодлогод нөлөөлөх замаар оролцоогоо идэвхжүүлж, зуучлах бодлого боловсруулж эхэлсэн юм.

Төрийн Департментын хэрэгжүүлэгч байгууллага болох БНСУ-д суугаа ДТГ-ын хувьд юу юунаас илүү дордож муудсан Япон, Өмнөд Солонгосын харилцааг сэргээхэд бүх боломж бололцоогоо дайчлан ажилласан гэж үзэж болно. Элчин сайд Даулин Япон, Умард Солонгосын хэлэлцээр байгуулагдахаас өмнө Япон, Өмнөд Солонгосын хэлэлцээрийг дахин эхлүүлж чадвал, яриа хэлэлцээрээр дамжуулан солонгос иргэдийг Умард руу илгээх ажлын хүрээг хумиж, үр дагаварыг бууруулж чадна гэж найдан, 4 дэх удаагийн яриа хэлэлцээрийг дахин эхлүүлэхэд бүх анхаарлаа хандуулан ажилласан юм. Түүний хичээл зүтгэлээр Япон дахь солонгос иргэдийг Өмнөд Солонгос руу шилжүүлэхийг санал болгосон БНСУ-ын Гадаад

хэргийн дэд сайд Ким Дун Жүгийн “бүтээлч төлөвлөгөө”-г Төрийн Департаментаас дэмжин, Япон, Өмнөд Солонгосын харилцааг сайжруулах 4 дэхь удаагийн яриа хэлэлцээрийг ямар ч болзолгүйгээр дахин эхлүүлэхэд зуучилсан юм. Эндээс олон улсын харилцаан дахь хувь хүн тоглогчийн үүрэг роль, нөлөө зэргийг харж болно. АНУ-ын хожуу оролцоо, солонгос иргэдийг Умард руу илгээх бодлогын үр дагаварыг багасгахыг оролдсон оролдлого амжилтанд хүрч чадаагүй хэдий ч уг асуудлаарх АНУ-ын байр суурь эрс өөрчлөгдөж, хоёр улсын харилцааны асуудал гэж үзэн, хөндлөнгөөс үл оролцох байр суурь баримталж байсан Төрийн Департамент солонгос иргэдийг Умард руу илгээх цар хүрээг хумих, үр дагаварыг багасгах чиглэлээр идэвхтэй оролцох байр суурь баримтлах болсон юм. Уг асуудлаарх АНУ-ын гадаад бодлогын чиглүүлэгч байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллагын байр суурь асуудал хөндөгдөж эхлэх үед нилээн ялгаатай байсан бол асуудал шийдэгдэх үед нэгдмэл байр суурьтай байж, хамтран ажиллах болсон нь юуны өмнө Зүүн Азийн бүс нутаг дахь АНУ-ын гадаад бодлогын гол тулгуур болсон Япон, өмнөд Солонгос хоёр улсын харилцаа улам бүр хурцадсан явдал, хоёрдугаарт, уг асуудлаас үүдэн бүс нутгийн энхтайван, чөлөөт лагерийнхны эв нэгдэлд учирч болох сөрөг нөлөө зэргийг бодолцсон байдал, гуравдугаарт, солонгос иргэдийг Умард руу илгээх асуудалд суугаа орныхоо байр сууринаас асуудалд уян хатан хандаж байсан ба АНУ-ын ДТГ-ын идэвхтэй үйл ажиллагаа, үүрэг рольтой шууд холбоотой гэж үзэж байна.

**НОМ ЗҮЙ:****Анхдагч эх сурвалж**

БНСУ-ын Гадаад Хэргийн яамны архивын баримт. Япон дахь солонгос иргэдийг Умард Солонгос руу буцаахтай холбоотой бичиг баримтууд (723.1 JA бүк V.2,3,4,6)

1. 재일한인 송환문제에 관한 대한적십자사 총재의 답신, 1956-9-4, 분류번호: 731 JA бүк 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0007-0011, 영어; 0012-0013, 한국어.
2. 재일한인 송환문제에 관한 대한적십자사 총재의 답신, 1956-9-4, 분류번호: 731 JA бүк 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0007-0011, 영어; 0012-0013, 한국어.
3. 최규하 이타가키와의 면담내용 보고, 공한 (TS-920288), 1959-1-30, 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 아주과, 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0032-0036, 영어
4. 재일한인 송환문제에 관한 국제적십자위원회의 서한, 1956-7-6, 분류번호: 731 JA бүк 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0005-0006, 영어.
5. 재일한인 북송의 진위여부 확인에 관한 것, 공한 (TS-920180), 1959-1-30, 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 아주과, 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0031, 영어
6. 최규하 이타가키와의 면담내용 보고, 공한 (TS-920288), 1959-1-30, 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 아주과, 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0032-0036, 영어
7. 재일한인 북송문제와 관련하여 Walter C.Dowling 미 대사와 가진 전화통화내용 보고, 공한 (MTB-021), 1959-1-31, 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0037-0039, 영어
8. 국회결의문. 1959-2-25, 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 아주과, 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0040-0043, 영어
9. 재일한인 북송문제에 대한 일본 측 답변, 1959-3-4; 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0044-0051, 영어
10. 재일한인 북송의 경위와 이의 부당성을 지적하며 한국정부의 입장을 16항목으로 정리한 문서. 1959-7-1; 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0055-0061, 한국어
11. 다울링 대사와 김동주 외무차관과의 회합. 1959-7-17; 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0064-0067, 영어
12. 다울링 대사의 외무차관에게 진한 의견서. 1959-7-21; 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0070-0072, 영어
13. 재일한인 북송문제에 한국 측 구두성명. 1959-7-21; 분류번호: 723 JA бүк 1955-60 V.2; 등록번호: 766; 필름번호: C1-0009, 파일번호: 02; 프레임번호: 0074-0075, 영어
14. 재일한인 송환문제에 관한 대한적십자사 총재의 답신, 1956-9-4, 분류번호: 731 JA бүк 1955-60, V.4, 등록번호: 768, 아주과, 필름번호: C1-0010, 프레임번호: 0007-00011, 영어; 0012-0013 한국어.

B. АНУ-ын Төрийн Департментын Архивын Дипломат Төлөөлөгчийн Газруудын бичиг баримт. (Record Group 84)

1. Gilstrap, 일본정부의 재일한인 자원 북송 결정과 관련된 한국 언론의 보도 경향을 국무장관에게 보고. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사

- 관 문서철. 1959-02-02. p. 5-6
2. MacArthur 주일 미대사의 후지야마 외상과의 면담내용 보고, 후지야마에게 전달 의견. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-09. p. 8-11
  3. MacArthur 주일미대사와 기시 수상의 대화 비망록, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-10. p. 12
  4. 미 국무차관, 한일 위기에 대하여 주미 한국공사와 로베르스 차관의 대화 요지를 주란미 대사관에 전달. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-14. p. 24-25
  5. MacArthur 주일미대사와 유태하 주일 한국대사의 대화내용 보고, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-10. p. 13-14
  6. Herter 국무장관 대리 재일한인 문제와 관련 국무부의 입장을 전달., 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-02-10. p. 47.
  7. 재일한인 북송문제에 관한 양유찬 주미 한국대사와 국무부 관계자 회의 비망록, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-03-05, pp. 86-89.
  8. Dillon 재일한인 북송문제는 자유 의지에 기초하여 이루어져야 한다는 국무부 입장 표명, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-06-27. p. 272.
  9. Herter 국문장관 이승만 대통령 자유선택의 원칙을 받아들이도록 설득할 것을 다울링에게 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-06-27. p. 349.
  10. Dowling 주한대사와 이승만대통령과의 논의. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-06-27. p. 354-355.
  11. Herter 국문장관이 김도조 외무차관의 건설적인 프로그램을 재확인 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-02, pp. 308.
  12. Herter 국무장관의 미국의 대응정책, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 6 (1959), 주일 미국 대사관 문서철. 1959-07-9, pp. 329-330.
  13. Herter 국문장관 이승만 대통령 자유선택의 원칙을 받아들이도록 설득할 것을 다울링에게 지시, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-09, pp. 349.
  14. Dowling 주한대사와 이승만대통령과의 논의. 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 7 (1959), 주한 미국 대사관 문서철. 1959-07-10, pp. 354-355.
  15. Mac Arthur 주일 미국대사 국무장관에게 보낸 전문, 국사편찬위원회, 한일회담 관계 미 국무부문서 6 (1959), 주일 미국 대사관 문서철. 1959-07-15, pp. 358.

### Хоёрдогч эх сурвалж

1. 강여린, “1959년 재일조선인 북한송환과 미국: 북송에 대한 미국의 입장변화 연구”, 서울대학교 석사학위 논문, 2013
2. 박정진, 2008, “북한의 대일접근과 재일조선인`북송(귀국) 문제`, 북한연구학회보 제 15 권 제 1 호, 219-246
3. 박정진, 2011, “재일조선인 북송문제와 일본의 귀국협력: 일조우호운동의 연속이라는 관점에서”, 사회와 역사 91, 2011, 09, p 31-60
4. 박정진, 재일조선인 귀국 (북송) 문제의 쟁점과 재론: 북한의 노동력 부족설을 중심으로 (화폐개혁 이후 북한의 변화상과 한반도 평화; 제2 발표)

5. 박진희, 「이승만의 대일인식과 태평양동맹」, 역사비평, (8) 2006, 90-118
6. 마츠우라 마사노부, “냉전기 재일한인 북송사업의 규모변용 과정에 관한 분석: 조총련과 북한로비의 역할을 중심으로”, 서울대학교 박사학위 논문, 2015
7. 신옥희, 「순응과 저항을 넘어서: 이승만과 박정희의 대미정책」, 서울대학교출판화원, 서울, 2010.
8. 신옥희, 「이승만의 역할인식과 1950년대 후반의 한미관계」 한국정치외교사논총, 26 (1), 2004, 37-61
9. 오일환, “특집논단:태평양 전쟁 희생자의 유골문제와 일본:1950년대 재중일본인, 재일 화교 및 유골 송환에 대한 연구-재일조선인 북송문제의 거울”, 『한일 민족문제연구』, 한일민족문제학회, 2005.
10. 이완범, 「재일교포 북송문제 연구」, 『해방후 한일관계의 쟁점과 전망』, 경인문화사, 서울, 2005.
11. 이재오, 「한일 관계사의 인식I: 한일회담과 그 반대운동」, 학민사, 서울, 1984.
12. 이현진, 「한일회담 외교문서를 통해서 본 재일한국인의 북한 송환」, 일본공감 연속 계획: 한일회담, 2008, 4, 212-232.
13. 이현진, 2010, “1950년대 후반 북송문제에 대한 한, 미, 일의 인식과 대응”, 일본연구 제 44 호, p 71-
14. Victor D. Cha, 「1965년 한일수교협정체결에 대한 현실주의적 고찰」, 한국국제정치, 13, 1, 1997.
15. 한일관계사연구논집 편찬위원회 편, 「해방 후 한일관계의 쟁점과 전망」, 경인문화사, 서울, 2005.